



МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

Агуулга

Нэг. Бүтэц зохион байгуулалт, хүний нөөц бусад үйл ажиллагаа

1.1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

1.2 Ажлын алба

Хоёр. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Нэг. 2.1 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Хоёр. 2.2 Холбооны дүрмийн 3.1.2-т заасан чиглэлээр

Гурав. 2.3 Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр

Дөрөв. 2.4 Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр

Тав. 2.5 Холбооны дүрмийн 3.1.5-д заасан чиглэлээр

Зургаа. 2.6 Холбооны дүрмийн 3.1.7-д заасан чиглэлээр

Долоо. 2.7 Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр

Найм. 2.8 Холбооны дүрмийн 3.1.9-д заасан чиглэлээр

Гурав.

3.1 Бусад

3.2 Санхүү, татвар

МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Д.Батбаатар
Монголын Шүүгчдийн холбооны Тэргүүн,
УДШ-ийн шүүгч



Г.Ганбаатар
Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



Ц.Оч
Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



Л.Эрдэнэбат
Удирдах зөвлөлийн гишүүн,
Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний
хэргийн ДЗШШ-ийн шүүгч



Ц.Мөнхтулга

Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Эрүүгийн хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



З.Ганзориг

Удирдах зөвлөлийн гишүүн,
Нийслэлийн Захиргааны хэргийн
ДЗШШ-ийн шүүгч



Н.Одонтуул

Удирдах зөвлөлийн гишүүн,
БЗД-ийн ЭХАШШ-ийн ерөнхий шүүгч



Ц.Эрдэнэчимэг

Удирдах зөвлөлийн гишүүн,
БГД-ийн ЭХАШШ-ийн шүүгч

1.2 Холбооны ажлын алба

Ажлын алба нь Монголын Шүүгчдийн холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хангаж, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2024 оны ажлын албаны бүрэлдэхүүн:


- ❖ Гүйцэтгэх захирал: Т.Туяа
 - ❖ Олон нийттэй харилцах хэвлэл мэдээллийн ажилтан М.Наранчимэг
 - ❖ Эрх зүйч, судлаач-гүйцэтгэх захирлын туслах ажилтан Б.Жавзандулам
- Нягтлан: Э.Тулгабаяр гэсэн бүрэлдэхүүнтэй ажилласан байна.


2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

2.1 Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг ажлын алба товлож, бэлтгэл ажлыг ханган, гаргасан тогтоолыг албажуулж, гишүүдэд мэдээлэх холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, гишүүн шүүгчдэд мэдээлэл хүргэх ажлыг ажлын алба тухай бүр хийж байна.

Шүүхийн үйл ажиллагааг мэдээлэх, гишүүн шүүгч нартаа тухай бүр мэдээлэл хүргэх, шүүгчийн ажлыг иргэд олон нийтэд үнэн зөвөөр таниулан сурталчлах зорилгоор холбооны вэб сайт болон пэйж хуудсыг хөгжүүлж шүүх, шүүгчийн талаарх албан ёсны мэдээллийг гол эх сурвалж болгон тухай бүр мэдээллийг шинэчлэн байршуулж байна. Мөн тайлант хугацаанд холбооны ажлын алба 38 тушаал гаргаж, 28 албан бичиг гаргаснаас ШЕЗ-д 8-г хүргүүлсэн байна.





2.2 Холбооны дүрмийн 3.1.2-т заасан чиглэлээр¹

➤ Төлөвлөгөөний 2.1, 2.2-т: Шударга ёсны хэмжүүр сэтгүүл²

Холбооны гишүүдийн эрдмийн болон чөлөөт уран бүтээлийг таниулах, сэтгүүлийг олон нийтэд хүргэх, Холбооны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийг жилд 2 удаа бэлтгэдэг. Тайлант хугацаанд сэтгүүлийн ээлжит 30, 31 дэх дугаарыг бэлтгэн Шүүгчдийн холбооны сайтад цахим хэлбэрээр байршуулсан.

Сэтгүүлийн 30 дахь дугаарт: МШХ-ны үйл ажиллагааны онцлох мэдээ мэдээлэл, орон нутгаас МШХ-той болон шүүхийн Тамгын газартай хамтран хийсэн шүүх болон шүүгчийг олон нийт, иргэдэд таниулах, үйл ажиллагааг сурталчлах, эрх

¹ 3.1.2. Шүүгчдийн мэдлэг, боловсрол, шүүн таслах ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахих чадварыг хэвшүүлэх, гишүүд мэдлэг, туршлагаа солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага, ном сэтгүүл хэвлэн гаргах;

² Шударга ёсны хэмжүүр сэтгүүл-
<https://judge.mn/%D1%81%D1%8D%D1%82%D0%B3%D2%AF%D2%AF%D0%BB/>

зүйн мэдлэг, мэдээлэл олгох хүрээнд хийгдсэн мэдээ, ярьж буй хууль нэвтрүүлэгт 2024 оны эхний хагас жилд орсон шүүгч болон зочин оролцогч, эрх зүйн төрөл сэдвүүдийн танилцуулга мэдээлэл, ШЕЗ-ийн дарга Л.Энхбилэгийн “ШЕЗ-ийн үндсэн чиг үүрэг, хүний нөөцийн асуудал” сэдвээр ярилцсан нэвтрүүлгийг ярилцлага хэлбэрээр буулгаж оруулсан ба Шүүгч Оюун-Эрдэнийн “Шүүхийн Тамгын ажилтны тулгамдсан асуудал” Эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг багтаасан.


31 дэх дугаарт: МШХ-ны тэргүүнийг нөхөн сонгосон сонгуулийн үр дүнгийн талаар, Joe Texas мужийн шүүхтэй танилцсан шүүгчдийн тэмдэглэл, Ахмад шүүгч А.Мөнхзултай хийсэн ярилцлага, Холбооноос хэрэгжүүлсэн ажлын тойм, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэлийн судлаач судалгааны ажил, тус сэтгүүлд Ахмад шүүгчдийн зөвлөгөө зэрэг булан үүсгэж шүүгчдэд хандаж хэлсэн сэтгэлийн үг зэргийг байршуулав.

Тус сэтгүүлийг холбооны сайтад /өнгөтөөр/ байршуулсан тул дэлгэрэнгүй үзэх, татаж авах боломжтой.



- Төлөвлөгөөний 2.3-т: ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд “Монголын Шүүгчдийн Холбооны үйл явдлын хураангуй” нэрээр холбооны үйл ажиллагааг нийтлэх

Холбооны үйл ажиллагааг өргөн хүрээнд таниулан сурталчлах, нийт шүүгчдэд хүргэх зорилгоор ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд “Монголын Шүүгчдийн Холбооны үйл явдлын хураангуй” нэрээр жилд 2 удаа үйл ажиллагаагаа танилцуулан байршуулдаг бөгөөд 2023 оны сүүлийн улирлын голлох ажлуудын талаар бэлтгэн ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд нийтлүүлсэн³. Холбооны үйл ажиллагааны 2024 оны эхний болон сүүлийн хагас жилийн голлох ажлуудын хураангуйг ШЕЗ-ийн “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлд хэвлүүлэхээр бэлтгэн хүргүүлсэн байна.



³ Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2023 он, Дугаар №4- https://judcouncil.mn/site/news_full/14091

➤ **Төлөвлөгөөний 2.4-т: ЧДИХАШ-ны шүүхтэй хамтран сургалт зохион байгуулав**

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхтэй хамтран 2024 оны 09-р сарын 13-нд Улсын дээд шүүхийн Иргэний танхимын шүүгч, судлаач Н.Баярмаа докторын ажлынхаа судалгааны онцлогийн талаар Монгол Улс дахь газар өмчлөлийн зэрэгцээ тогтолцоо, газрын шинэтгэл түүний үр дагавар, Монгол Улсын газрын харилцааны нэгдмэл байдал, газар ашиглалт төрөөс баримталж буй бодлого, өнөөгийн хууль хэрэглээнд хийсэн ажиглалт шинжилгээ, зарим гадаад орны газрын харилцааны эрх зүйн зохицуулалт зэрэг судалгааны ажлынхаа шинэлэг байдал, үр дүнгийн талаар шүүгчдэд танилцуулсан юм.



Уулзалтад БЗД, СБД, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид оролцсон байна.

➤ **Төлөвлөгөөний 2.5-д: Хувь хүний хөгжил, сэтгэл зүйн боловсролын талаарх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав**

Шүүгчдийн холбооны 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу ахмад гишүүдийн санаачилсан Сэтгэлийн боловсрол олгох сургалтын хүрээнд 2024 оны 12-р сарын 16-ны өдөр Монголын Шүүгчдийн холбооны байранд ахмад шүүгч нарт “Сэтгэл хөдлөлийн чадамжийн тухай авч үзэх нь” сэдвээр Сэтгэл судлаач,



МУИС-ийн сэтгэл судлалын багш, докторант Ж.Айганым илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэн шүүгчидтэй харилцан санал солилцсон.



Гурав. 2.3 Холбооны дүрмийн 3.1.3-д заасан чиглэлээр⁴

➤ Төлөвлөгөөний 3.2-д тусгасан: “Шинэ үе нээлттэй шүүх” төслийг үргэлжлүүлэх

Тус холбооны УЗ-ын гишүүн асан УДШ-ийн шүүгч Н.Баярмаа “Шинэ үе нээлттэй шүүх” төслийг УДШ-ийн Тамгын газар, Шүүхийн академийн дэмжлэгтэйгээр Хүүхдүүд асууж байна сэдвээр хийгдэж байна⁵.

Энэхүү төсөл нь УДШ-ийн гишүүн шүүгчдийн оролцоотой явагдаж байгаа бөгөөд холбооны гишүүдийг хамруулан үргэлжлүүлэх болно. Цаашид шүүгчдийн холбоо энэхүү эрх зүйн боловсрол олгох цуврал контентыг холбооны шүүгч гишүүдийг хамруулан өөрийн сайт, пэйж хуудсанд байршуулан үргэлжлүүлэн хүргэх болно.

⁴ 3.1.3. Шүүхийн бие даасан, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн хурал зохион байгуулах

⁵ "Хүүхдүүд асууж байна" контент-https://fb.watch/wVeu_RcSRq/

Таны бодлоор шүүгч гэж хэн бэ?



Дөрөв. Холбооны дүрмийн 3.1.4-д заасан чиглэлээр⁶

- Төлөвлөгөөний 4.1, 4.3-т тусгасан: Гадаад харилцааг өргөжүүлж, шүүхийн үйл ажиллагаа болон шүүгчдийн сургалт судалгааны чиглэлээр харилцан туршлага солилцох

- 2024 оны 4-р сарын 22-нд АНУ-ын SJF (Spurlock Judicial Foundation) сангийн төлөөлөгч, хуульч Г.Ганзориг Шүүгчдийн холбооны төлөөл уулзалт хийж тус сантай өмнөх харилцааг үргэлжлүүлж гадаад сургалт зохион байгуулах хугацаа сэдвийн талаар харилцан санал солилцсон. Уулзалт хийж тус сангийн шугамаар АНУ-ын шүүхтэй танилцах болон эрх зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах талаар харилцан санал солилцсон. Түүнчлэн тус сангаас ирүүлсэн “Ирээдүйн хуульч” тэтгэлгийн мэдээллийг менторшип хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж буй Шихихутуг их сургуулийн сургалтын албанд удирдамжийг хүргүүлсэн.

⁶ 3.1.4. Гадаад, дотоодын ижил зорилго бүхий байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах, шүүгчдийн сургалт, айлчлалыг харилцан зохион байгуулах, түүнчлэн шүүгчид дээрх байдлаар харилцаа тогтоох, харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;

“ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ, ШҮҮГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЭВ

АНУ-ын Spurlock Judicial Fund байгууллагатай хамтран 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Шүүгчийн ёс зүй, шүүгчийн сэтгэл зүй сэдэвт хэлэлцүүлгийг бүх шатны шүүхийн шүүгчид танхим болон цахимаар оролцуулан зохион байгуулсан.




Хэлэлцүүлгийг УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч, Шүүгчдийн холбооны Тэргүүн Д.Батбаатар нээж, УДШ-ийн Иргэний хэргийн танхимын Тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн нар тус хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр ажиллав.

БЗД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Н.Одонтуул "Шүүгчийн ёс зүйн зарчим, Монгол Улсын шүүхийн туршлага" сэдвээр, Техас мужийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Michelle Slaughter "Шүүгчийн ёс зүй АНУ-ын шүүхэд" АНУ-ын шүүхийн тогтолцоо шүүхийн хараат бус байдлыг хангах, Техас мужийн Шүүгчийн ёс зүйн дүрмийг Миссори мужийн шүүхийн томилгооны тогтолцоотой харьцуулах нь", "Шүүгчийн ажлын стресс, стресс тайлах арга туршлага" сэдвээр, Техас мужийн анхан шатны шүүхийн шүүгч, профессор Judge Matthew Wright "Шүүгчийн сэтгэл зүй, шүүгч сэтгэл хөдлөлөө удирдах нь" сэдвээр тус тус илтгэл тавьж, оролцогч шүүгчидтэй харилцан хэлэлцүүлэг өрнүүлсэн. Профессор Judge Matthew Wright "Шүүгчийн сэтгэл зүй, шүүгч сэтгэл хөдлөлөө удирдах нь" сэдвээр илтгэл тавьсан.



Тус хэлэлцүүлэгт танхим болон цахимаар 100 гаруй шүүгч оролцсон байна.



Хэлэлцүүлгийн хөтөлбөр:

АНУ-ын SPURLOCK JUDICIAL FUND болон МОНГОЛЫН ШҮҮГЧИЙН ХОЛБОО
хамтран хэрэгжүүлж буй “Шүүгчийн ёс зүй, Шүүгчийн сэтгэл зүй”
сэдэвт хэлэлцүүлгийн хөтөлбөр

Хэлэлцүүлгийн огноо: 2024 оны 05 дугаар сарын 13


Хамрах хүрээ: Бүх шатны шүүгчид /танхимаар 30 шүүгч, онлайн 20 /



Хаана: Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 102 тоот

ЦАГ	СЭДЭВ	ИЛТГЭГЧ, ОРОЛЦОГЧ
09:00-09:05	Хэлэлцүүлгийн нээлт	Улсын Дээд Шүүхийн шүүгч, МШХ-ны Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Багбаатар
09:05-09:20	Шүүгчийн ёс зүйн зарчим, Монгол Улсын шүүхийн туршлага	Баанзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Н.Одонтуул
09:20-09:40	Шүүгчийн ёс зүй АНУ-ын шүүхэд АНУ-ын шүүхийн тогтолцоонд шүүхийн хараат бус байдлыг хангах, Техас мужийн Шүүгчийн ёс зүйн дүрмийг Миссори мужийн шүүхийн томилгооны тогтолцоотой харьцуулах нь!	Michelle Slaughter /Техас мужийн давж заалдах шатны шүүхийн шүүгч /
09:40-10:10	Шүүгчийн сэтгэл зүй, шүүгч сэтгэл хөдлөлөө удирдах	Judge Matthew Wright /Техас мужийн анхан шатны шүүхийн шүүгч, профессор / Панелист: Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Ёс зүйн зөвлөх хорооны гишүүн Б.Батцэрэн
10:10-11:00	Шүүгчийн ёс зүй, сэтгэл зүй, шүүгч сэтгэл хөдлөлөө удирдах сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэгт оролцогч шүүгч нар

11:00-11:20	Цайны завсарлага	Монголын Шүүгчдийн Холбоо
11:20-11:50	Шүүгчийн ажлын стресс, стресс тайлах арга туршлага	Michelle Slaughter /Техас мужийн давж заалдах шатны шүүхийн шүүгч / Judge Matthew Wright /Техас мужийн анхан шатны шүүхийн шүүгч, профессор / Панелист: Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч Г.Алтанчимэг
11:50-12:50	Шүүгчийн ажлын стресс, стресс тайлах арга туршлага сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэгт оролцогч шүүгч нар
12:50-13:00	Хэлэлцүүлгийн хаалт	Улсын Дээд Шүүхийн шүүгч, МШХ-ны Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Багбаатар

Илтгэл тавьсан шүүгч нарын танилцуулга:



Эрхэм Мишел Слатер
Шүүгч – Техас мужийн Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүх (Эрүүгийн хэргийн Дээд шүүх)



Эрхэм Мэттью Г. Райт
Шүүх хурлын шүүгч, Springock шүүхийн сангийн УЗ-ийн гишүүн & Төлөөлөгчдийн тэргүүн

Мишел Слатер шүүгч 2018 онд Техас мужийн Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүхэд сонгогдсон. 2018 оны 11 дүгээр сард болсон бүх нийтийн сонгуульд Слатер шүүгч 4.7 сая гаруй санал авч, Америкийн нэгдсэн улсын хэмжээнд Бүгд найрамдах намаас өрсөлдсөн бусад бүх өрсөлдөгчдөөс илт давуу санал авсан байна. Шүүгчийн алба хаахын хажуугаар тэрээр Бэйлор Хуулийн сургуульд улирал тутамд зохиогддог Эрүүгийн эрх зүйн эрчимжүүлсэн сургалтанд туслах профессороор ажилладаг.

Шүүгч Слатер Хьюстоны Их Сургуулийн Хуулийн төвийг J.D. /Juris Doctor/ зэргийг онц дүнтэй (шилгэд 15%) төгссөн. Тэрээр хуулийн сургуульд суралцаж байхдаа Холбооны дүүргийн шүүхийн хоёр шүүгчид, мөн Техас мужийн Давж заалдах шатны Нэгдүгээр шүүхэд мэргэжлийн дадлага хийж байсан байна. Мөн тэрээр мэргэшсэн эвлэрүүлэн зурчлагч болж, Better Business Bureau (орч.Илүү Сайн Бизнесийн Товчоо) болон дэг журмын шүүхийн олон хэргүүдийг амжилттай эвлэрүүлсэн байна. Хуулийн сургуулиа төгсөөд Олон улсын хэмжээний хоёр том хуулийн фирмд шүүх хуралдааны өмгөөлөгчөөр ажиллаж, хуулийн мэргэжлээр амжилттай туршлага хуримтлуулсан. Тийнхүү өмгөөлөгчөөр ажилласны үр дүнд тэрээр Техас мужийн Сар тутмын сэтгүүлийн Супер Хуульчид хэвлэлийн "Мандаж буй Од" цолыг хүртсэн байна.

Шүүгч Слатер хуулийн сургуульд суралцахын өмнө ТВ болон киноны салбарт ажиллаж байсан. Тэрээр Arlington Road нэртэй кино болон, JAG, The Practice, Judging Amy зэрэг ТВ шоуууд дээр ажилласан байна. Тэр байтугай кинонд жүжигчин Сандра Буллокын орон тоглогчоор оролцсон билээ. Шүүгч Слатер нь коллежийн дурлалт залуу, сайн найз болох НАСА-ийн инженер ажилтай Эд Уолштой гэрлэсэн. Тэд хамтдаа Хазел, Лайла хэмээх есвөр насны хоёр гайхалтай охинтой.

АНУ-ААС ИРСЭН ШҮҮГЧИДТЭЙ АЖИЛ ХЭРГИЙН УУЛЗАЛТ ХИЙВ

2024 оны 5-р сарын 13-нд Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүд Улсын дээд шүүхийн уулзалтын танхимд Техас мужийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Michelle Slaughter, Техас мужийн анхан шатны шүүхийн шүүгч, профессор Judge Matthew Wright болон дагалдан яваа бусад хуульчидтай ажил



хэргийн уулзалт зохион байгуулав. Тус уулзалтаар МШХ-ны Тэргүүн Д.Батбаатар

Холбооны үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, УЗ-ийн гишүүдээс цаашид хамтран ажиллах, шүүгч гишүүдийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн туршлага солилцох зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх талаар санал солилцож энэхүү саналыг зочин шүүгчид нааштайгаар хүлээн авсан үр дүнтэй уулзалт болсон.

“Ирээдүйн хуульч” тэтгэлэг

Түүнчлэн тус сангаас ирүүлсэн “Ирээдүйн хуульч” тэтгэлгийн мэдээллийг менторшип хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж буй Шихихутуг их сургуулийн сургалтын албанд удирдамжийг хүргүүлсэн.



Spurlock Judicial Fund
PO Box 522, Rosebud, Texas 76570 USA

Спурлок Сангийн “Ирээдүйн хуульч” тэтгэлэгийн тухай

Тэтгэлэгийн зорилго

Спурлок Сангийн (цаашид Сан) “Ирээдүйн хуульч” тэтгэлэг нь, Монгол Улсын хуулийн сургуульд суралцаж байгаа, Монгол Улсын иргэн, ирээдүйн хуульч оюутан залуусын сургалтын төлбөрт нэмэр хандив оруулж, тэднийг урамшуулан, дэмжих замаар Монгол Улсын шүүхийн шинэтгэлд тус дэмжлэг үзүүлэх зорилготой болно.

Тэтгэлэгт хамаарагдах хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт

1. Тэтгэлэгт хамаарагдах хүсэлт, түүнийг хүсэх болсон үндэслэл шалтгаан, тэтгэлэг хүртснээр хүрэх зорилго, үр дүн, амжилт бүтээлийн тухай богино өгүүлэл.
2. Аль нэг хуулийн сургуулийн 3 эсвэл 4 дүгээр ангид суралцаж байгаа тухай тодорхойлолт, нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүн (энэ нь харгалзах үзүүлэлтэд хамаарна).
3. Сургалтын төлбөрөө төлөх санхүүгийн боломж хязгаарлагдмал байдлыг нотлох ам бүл, өрхийн орлогын талаарх сум, баг хорооны тодорхойлолт, бусад бичиг баримт Үгэл шалгуур үзүүлэлт болно.
4. Иргэний үнэмлэхийн хуулбар.
5. Паспортын зургийн хэмжээний нэг хувь зураг.

6. Оюутан нь, тэтгэлэгт хамаарагдах Журмын шаардлагыг хангасан, хүлээн зөвшөөрсөн байна.

Хүсэлт, бусад бичиг баримтыг өрдийн шуудан, цахим шуудангаар, монгол эсхүл англи хэл дээр дараах хаягаар ирүүлнэ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 6
АБ Төв, “Өмгөөллийн үйл ажиллагааг дэмжих төв” ТББ, Өрөө 803

Цахим шуудан: batsukh.do@adconsulting.mn

Тэтгэлэгт хамааруулах шалгуур (Хэсэгчлэн дурдав)


1. Хичээлийн жилд нэг удаа, 500 ам доллартай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлгийг сургуулийн дансаар шилжүүлэн оюутанд олгоно.
2. Тэтгэлэгийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлнэ.
3. Тэтгэлгийг нэг оюутанд зөвхөн нэг удаа олгоно.
4. Тэтгэлгийг зөвхөн сургалтын төлбөрт зориулан ашиглана.
5. Тэтгэлэг олгох журмыг зөрчсөн нь тогтоогдвол, оюутан буцааж нөхөн төлөх үүрэг хүлээнэ.
6. Тэтгэлгийг зарцуулсан улирлын сургалт дууссаны дараа 90 хоногийн дотор тэтгэлгийг хэрхэн зарцуулсан, ямар үр дүнд хүрсэн тухай оюутны товч тайланг ТББ хүлээн авч, Санд хүргүүлснээр тухайн жилийн тэтгэлэг олгох, тайлан гаргах ажиллагаа дуусгавар болно.

АНУ-н Техас мужийн Даллас хотод зохион байгуулагдсан сургалт, соёлын үйл ажиллагаа

2024 оны 5-р сарын 28-нд АНУ-н Spurlock Judicial Foundation сангийн хамтын ажиллагааны хүрээнд АНУ, Техас мужийн, Dallas хотод зохион байгуулагдах

сургалтад 10 шүүгч оролцуулах болсон талаар тус сангийн Монгол дахь төлөөлөгчтэй уулзалт хийсэн.

Техас явах шүүгчдийг тодорхой шалгуурт үндэслэж явуулах талаар УЗ хуралдаанаар хэлэлцэж сонгон шалгаруулалтыг УЗ-ийн хурлаар хэлэлцэж гишүүн шүүгчдийн групп болох МШХ; МШХ Салбар тэргүүн хаягуудад мэдээллийг байршуулав.



Монголын Шүүгчдийн Холбоо
May 28, 2024 · 🌐

#Мэдээлэл

МШХ болон АНУ-н Spurlock Judicial Foundation сангийн хамтын ажиллагааны хүрээнд 2024 оны 09 сарын 26-ны өдрөөс 10 сарын 5 ны хооронд АНУ, Техас муж, Dallas хотод зохион байгуулагдах сургалтад 5 шүүгч оролцуулах боломжтой боллоо. Сонгон шалгаруулалтыг МШХ-ны УЗ хийж, нэрсийг Sporkluck санд явуулах болсон тул сонирхсон шүүгч нар өөрийн товч танилцуулга материалаа холбооны contact@judge.mn хаягаар 6 сарын 2-ны дотор ирүүлнэ үү.

Явах шүүгч нар замын зардал буюу 2 талын тийзны үнэ, визний хураамж, аялалын даатгалын хураамж болон хөтөлбөрөөс гадуурх зардлаа өөрсдөө хариуцна. Дээрх хугацаанд тэнд байрлах буудал, өдөр оройн хоол хот доторх зам тээврийн зардлыг сангаас хариуцна. Сонгон шалгаруулалт хийхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ.

Үүнд:

- 1) 5-с дээш жил шүүгчээр ажилласан байх,
- 2) МШХ-ны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог,
- 3) холбооны татвар бүрэн төлсөн,
- 4) энэ төсөл арга хэмжээнд оролцож ирээд цаашид бусад төсөл арга хэмжээнд гар бие оролцож, холбооны үйл ажиллагааг дэмжих чин хүсэл эрмэлзэлтэй байх.
- 5) өөрсдийн зүгээс төлөх зардлуудыг бүрэн хариуцах боломжтой байх
- 6) зохих хэмжээний англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Шүүгч нар өөрсдийн танилцуулгаа ирүүлэхдээ АНУ-ын визтэй эсэхээ бичнэ үү.

МШХ-ны ажлын алба.

👍 Munkhtulga Tserenchimed, Adiyasuren Baatar and 19 others


Дээрх мэдээллийн дагуу тухайн сургалтад хамрагдахаар 10 шүүгч хүсэлт ирүүлж, түүнээс тодорхой шалгуур хангасан 6 шүүгч, УЗ-ийн 4 гишүүн шүүгч хамрагдах болов.

2024 оны 09 сарын 26-ны өдрөөс 10 сарын 05-ны хооронд АНУ, Техас муж, Dallas хотод сургалт, соёлын үйл ажиллагаанд дээрх 10 шүүгч амжилттай оролцов.



Сургалтад хамрагдсан шүүгчдийн бэлдсэн танилцуулга:



Сургалтын эхний өдөр АНУ-ын Техас мужийн Texas A&M University их сургуулийн хуулийн сургуульд зочилж, сургуулийн үйл ажиллагаа, номын сантай танилцаж, судалгаа хийх арга зүйн талаар, АНУ-ын шүүхийн тогтолцоо, жишиг тогтоосон шүүхийн шийдвэрүүдийг хэрхэн хайж олох зэрэг сэдвээр танилцуулга, илтгэл сонсож, хэлэлцүүлэг өрнүүлэв.



Spurlock Judicial Foundatoin сангийн төлөөлөгч нар биднийг угтан авлаа.



Сургуулийн номын санд 200 гаруй жилийн өмнөөс өнөөг хүртэлх АНУ-ын Дээд шүүхийн шийдвэрүүд хэвлэмэл байдлаар хадгалагдаж байна.

Номын сангаар оюутнууд болон өмгөөлөгч, прокурор, иргэд үйлчлүүлэх боломжтой бөгөөд ажилтнууд нь судалгааны ажил хэрхэн хийх талаар сургалт ордог.




Шүүгч Joe Spurlock тус сургуульд хичээл зааж байсан аж. Түүний ажиллаж байсан өрөөний үүдэнд уйгаржин монгол бичгээр нэрийг бичсэн дурсгалын самбар байрлуулжээ.



Профессор, багш нар танилцуулга хийж, илтгэл тавьсантай холбогдуулан хэлэлцүүлэг явууллаа. Texas A&M University хуулийн сургуулийн захирал Robert Ahdien сургуулийнхаа үнэт зүйл болсон 6 уриаг танилцуулж, нийтийн тусын тулд нийтэд үйлчлэх үйл хэрэг сургуулийнх нь хувьд маш чухал болохыг онцоллоо.

МШХ-ноос тус сургуульд Монгол Улсын түүх (англи хэл дээр) болон МШХ-ны гишүүн, шүүгчдийн эрдмийн бүтээлийг бэлэглэлээ.



Шүүгчдийн төлөөлөл Техас мужийн Давж заалдах шатны 10 дугаар шүүхтэй танилцлаа.



Техас муж нь давж заалдах шатны 14 шүүхтэй.

Техас мужийн Давж заалдах шатны 10 дугаар шүүхэд 3 шүүгч ажилладаг, шүүгчдэд санамсаргүй тохиолдлоор хэрэг хуваарилагддаг.

Хэргийн оролцогч анхан шатны шүүхийн шийдвэртэй танилцаад зөвшөөрөхгүй тохиолдолд давж заалдах мэдэгдэл өгч хугацаа тоологддог бөгөөд нэмэлт тайлбар, гомдлоо тусад нь бичиж өгнө.

Ерөнхий шүүгч Matt Johnson шүүхийн үйл ажиллагаа, давж заалдах журам, шүүгч, прокурор, өмгөөлөгч талын чиг үүргийн талаар танилцуулга хийв.




Жишиг тогтоосон шүүхийн шийдвэрүүд анхан шатны шүүхэд удирдамж болдог, мөн хуульч өмгөөлөгч, прокурор нь тухайн хэрэгт давж заалдах эсэх нь жишиг тогтоосон шийдвэрээс хамаардаг гээд давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа, мөн ялын тохиролцоо, Техасын барын холбооны гишүүн хуульчид мөрдөх нэгдсэн дүрэмтэй, зөрчил гаргавал хуульчийн эрхийг хасах, шүүгч зөрчил гаргавал ёс зүйн хороо шийдвэрлэх талаар танилцуулж, шүүгчдийн сонирхсон асуултад хариулав.

Тэрээр давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж байгаа хуульчид анхан шатны шүүхийн шүүгчийн алдаанд дөрөөлж гомдол гаргаж байгаа тул тэр нь бидэнд сургамж болдог гэж онцлоод яриагаа дуусгав.




Hill County-Хилл тойргийн шүүх

Шүүгч Justin Lewis шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрлэх хэрэг маргааны талаар танилцуулга хийв.



Шүүх хуралдааны танхим, шүүгчийн ажлын өрөө, шүүгчийн туслахын өрөө




Baylor University-д зочилоход оюутнууд угтан авч сургуулиа танилцуулж, 2 орны соёлын талаар харилцан ярилцлаа. Мөн оюутнууд сургуулийн дэргэдэх үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох Dr Pepper ундаагаар дайлж яриа өрнүүллээ.

Техас мужийн шүүхийн тогтолцоо

Техас мужид 5 шатны шүүх ажилладаг

- Municipal and Justice Courts /Хотын захиргааны шүүх болон Үнэн шударгын шүүх/
- County Courts at Law /Сумын шүүх/
- District Courts /Дүүргийн шүүх/
- Courts of Appeal /Давж заалдах шатны шүүх/
- Supreme Court and Court of Criminal Appeals /Мужийн Дээд шүүх болон Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх-Эрүүгийн хэргийн Дээд шүүх/



Justice Court буюу Үнэн шударгын шүүх

Үнэн шударгын шүүх нь замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчил, 10.000 доллар хүртэлх иргэний нэхэмжлэл, албадан саатуулах ажиллагаа, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн хохирогчийг хамгаалах захирамж, дарамт шахалт үзүүлэхийг хориглосон захирамжийг гаргадаг.

County Courts at Law буюу Сумын шүүх

Иргэний болон Эрүүгийн хэргүүдийг хянан шийдвэрлэдэг. Энэ шүүхийн шүүгч эрүүгийн жижиг хэрэг, иргэний хэрэг, өв залгамжлал, хүүхдийн асуудал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг хянан шийдвэрлэдэг. Шүүгч тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид голлох үүрэгтэй оролцдог албан тушаалтан байдаг. Тэдний хариуцлага нутаг дэвсгэрээс шалтгаалж өөр өөр байдаг боловч дараах үүрэгт хамаарч болно. Үүнд, сонгууль зохион байгуулах, шар айраг болон дарсны зөвшөөрлийн өргөдлийн сонголт явуулах, тойргийн төсөв батлах, тухайн засаг захиргааны нэгжийн татварын хэмжээг тогтоох, дэд бүтэц, шүүхийн байр, шорон барих болон засварлах ажлыг хянах, онцгой байдлын удирдлагын эрх мэдлийг хэрэгжүүлдэг.

Тус шүүхийн шүүгч Барын холбооны гишүүн байхыг шаардахгүй тул бусад шүүхэд өмгөөлөгчөөр, эсвэл бусдыг төлөөлөн оролцох боломжтой байдаг.

Municipal Court буюу Хотын захиргааны шүүх

Техас мужид Хотын захиргааны шүүх (Municipal court) болон Үнэн шударгын шүүх (Justice court нь) нэг түвшинд хэрэг хянан шийдвэрлэх хэдий ч эрх мэдэл, шийдвэрлэж буй хэргийн төрөл нь өөр өөр байдаг.

Хотын захиргааны шүүх нь тухайн хотын захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдлүүд, мужийн хууль дүрмийг зөрчсөн тухайн хотын хууль дүрмийн хүрээнд шийдвэрлэгдэх жижиг гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэдэг. Түүнчлэн иргэний зарим хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг байна. Жишээ нь, авто тээврийн хэрэг, тэжээвэр нохой нь бусдад аюул учруулсан хэрэг гэх мэт. Тус шүүхийн шүүгч нар нь тухайн хот сууринд нэр хүндтэй иргэн байх ба гэмт хэргийн шинжтэй тээврийн хэргүүдийг хянан шийдвэрлэж, эрэн сурвалжлах захирамж, хамгаалалт хорио цээрийн захирамж шийдвэрүүдийг гаргадаг байна.




District Courts- Дүүргийн шүүх

Дүүргийн шүүхүүд нь Техас мужийн ерөнхий харьяаллын анхан шатны шүүх юм. Хууль тогтоогчоос бүс нутаг бүр нэг дүүргийн шүүхтэй байна гэж хуульчилсан хэдий ч хүн ам цөөн хэд хэдэн хот дундаа нэг дүүргийн шүүхтэй, харин хүн ам ихтэй хот суурин газарт хэд хэдэн дүүргийн шүүх үйл ажиллагаа явуулдаг.

Дүүргийн шүүх нь хүнд эрүүгийн гэмт хэрэг, гэр бүл салалтын хэрэг, газар өмчлөхтэй холбоотой хэрэг, сонгуулийн өрсөлдөөний хэрэг, хохирлын хэмжээ 200 доллар ба түүнээс дээш байх иргэний хэрэг, аль ч шүүхэд харьяалагдахгүй зарим хэргийг хянан хэлэлцдэг.

Ихэнх дүүргийн шүүх нь эрүүгийн болон иргэний хэргийн аль алиныг нь хэлэлцдэг бол хүн ам ихтэй хотын дүүргийн шүүх нь иргэний хэрэг, эрүүгийн хэрэг, өсвөр насны иргэдийн хэрэг, гэр бүлийн хэргийн чиглэлээр төрөлжин үйл ажиллагаа явуулдаг байна.



Appellate Courts буюу давж заалдах шатны шүүх

Давж заалдах шатны шүүх нь дүүргийн шүүх, үнэн шударгын шүүхийн шийдвэрт гомдол гаргасан иргэний болон эрүүгийн хэргүүдийг хянан хэлэлцдэг. Техас муж нь давж заалдах шатны 14 шүүхтэй ба нийт 80 шүүгч ажилладаг. Нэг давж заалдах шатны шүүхэд 1 ерөнхий шүүгч, 2 болон түүнээс дээш шүүгч ажилладаг. Давж заалдах шатны нэг шүүхэд доод тал нь 3 шүүгч, дээд тал нь 13 шүүгчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулдаг байна.

Давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан "en banc hearing" буюу тухайн шүүхийн шүүгч нар бүгд оролцох шүүх хуралдаанаас бусад тохиолдолд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан хэлэлцдэг.



The Texas Supreme Court- Техас мужийн дээд шүүх

Техас мужийн Дээд шүүх нь иргэний болон насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэдэг хамгийн дээд шатны шүүх юм. Дээд шүүх нь Ерөнхий шүүгч болон найман шүүгчээс бүрддэг бөгөөд бүгд зургаан жилийн хугацаатайгаар иргэдээс сонгогддог.

Түүнчлэн Дээд шүүх нь шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс давж заалдах шатны 14 шатны шүүх хооронд хэргийг шилжүүлэх эрхтэй байдаг.

Техас мужийн Дээд шүүх нь Техас мужийн Остин хотод байрладаг.

Court of Criminal Appeals- Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх буюу эрүүгийн хэргийн Дээд шүүх



Техас мужийн Остин хотод байрлах Дээд шүүх нь тус мужийн эрүүгийн хэргийн хамгийн дээд шатны шүүх юм.

Ерөнхий шүүгч болон найман шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажилладаг бөгөөд шүүгчид нь мужийн иргэдийн саналаар 6 жилийн хугацаагаар сонгогддог.

Эрүүгийн хэргийн дээд шүүх нь заримдаа нүүдэллэн ажиллаж мужийн өөр хотод шүүх хуралдаанаа явуулдаг.

Канадын хамтын ажиллагаа

2024 оны 01-р сарын 23-ны өдөр МШХ-ны тэргүүн агсан Ж.Оюунтунгалаг, Гадаад харилцааны дэд хорооны гишүүн Ц.Эрдэнэчимэг, Ц.Мөнхтулга, Б.Батаа нар Канад Улсын Дээд Шүүхийн Шүүгчдийн Холбооны тэргүүн Мона Линч шүүгчтэй онлайн уулзалт зохион байгуулж, уулзалтын хүрээнд 2 улсын шүүгчдийн холбооны цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2024 оны 5-р сарын 15-нд Хангарди ордонд байрлах Шүүгчдийн холбооны байранд УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын Тэргүүн, Шүүгчдийн холбооны дэргэдэх Шүүгчийн ёс зүйн зөвлөх хорооны ахлагч, шүүгч Д.Мөнхтуяа, МШХ-ны Тэргүүн Д.Батбаатар, Удирдах зөвлөлийн зарим гишүүд, ажлын албаны төлөөлөл уулзалт хийж нар Канад Улсын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх газрын олон улсын хөтөлбөрийн дарга Олег Шаковтой ажил хэргийн уулзалт хийв.

Тус уулзалтын зорилго нь Монгол Улсад “ХҮН БҮРД ШУДАРГА ЁС, ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ” төслийн зөвлөлдөх баримт бичигт тусгагдсан агуулгын хүрээнд МШХ ямар үйл ажиллагаанд хамтран оролцох боломжтой талаар ярилцаж, санал бодлоо хуваалцав.



Тус төсөлд тусгагдсан “Шүүхийн үйл ажиллагаанд жендерийн мэдрэмжтэй, иргэн төвтэй байдлыг дээшлүүлэх” агуулгад багтсан Шүүхийн тогтолцооны ил тод байдлыг нэмэгдүүлэн иргэдийн мэдлэг, ойлголт, харилцаа хандлагыг сайжруулах, олон нийтэд зориулсан эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй болгоход Шүүгчдийн холбоо хамтран ажиллах бүрэн боломжтой талаар саналаа илэрхийлэв.

Шүүгчдийн холбооны тэргүүн Д.Батбаатар төслийн хүрээнд холбооны цахим хуудас, вэб хөгжүүлэлтийг дэмжиж үйл ажиллагааг өргөтгөх шаардлагатай, тухайлбал гишүүдийн бүртгэл, онлайн хурал, дотоод холбоос хөгжүүлэх, шүүгчийн ёс зүйн зөвлөх хорооны хөтөч хуудас нээх гэх мэт мөн Канадын туршлага судлах үйл ажиллагаанд Шүүгчдийн холбооны шүүгч гишүүдийг хамруулах талаар санал хэлсэн.

Мөн холбооны дэргэдэх Шүүгчийн ёс зүйн зөвлөх хорооны ахлагч, УДШ-ийн шүүгч Д.Мөнхтуяа нь УДШ, ШЕЗ, ШСХ нь шүүгч нартай нээлттэй харилцаа тогтоох боломж харьцангуй хязгаарлагдмал байдаг бол Шүүгчдийн холбоо нь шүүгч нартай харилцахад илүү нээлттэй, илүү хүртээмжтэй ажиллах боломж өргөн байдаг учраас төслийг МШХ-той хамтран хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэсэн саналыг хэлэв. Мөн Шүүгчдийн холбооны дэргэдэх ёс зүйн зөвлөх хороо 9 шүүгчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлсэн хэдий ч шүүгчдэд мэдээллийг шүүгчдэд хэрхэн хүргэх, хүсэлт авах, гаргасан зөвлөмжийг хүргэх суваг байхгүй байгаа, ойрын хугацаанд холбооны вэб сайтад дэд бүтэц үүсгэж, тухайн зөвлөмж авсан шүүгч зөвшөөрсөн тохиолдолд тухайн зөвлөмжтэй танилцах, санал бодлоо илэрхийлэх боломжтой платформтой болно гэж төсөөлж байна. Мөн шүүх хүний нөөцийн хомсдолтой байгаа учраас тэтгэвэрт гарсан ахмад шүүгч нартай ажиллах, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах шаардлага байгаа талаар саналаа хэлэв.

Шүүгчдийн холбооны үйл ажиллагаанд бүх шатны шүүгчид хүртээмжтэй оролцох боломжтой байдаг учраас шүүгчдийн оролцоог идэвхжүүлэн иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээх үйл ажиллагаанд иргэд рүү чиглүүлсэн шүүхийн нэр хүндийг өсгөх, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх олон талын ажлыг хийх нөөц бололцоо байгаа тухай нээлттэй ярилцсан уулзалт болсон юм.

➤ **Төлөвлөгөөний 4.4 -д: АТГ-тай хамтран “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийсэн постер хуулийн байгууллагуудад түгээх**

2023 онд Монголын Шүүгчдийн холбоо, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, Соён гэгээрүүлэх хэлтэс хамтран холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжин туслах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоо, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, дэмжих зорилт бүхий хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тус хамтын ажиллагааны дагуу УДШ-ийн Эрүүгийн танхимын Тэргүүн Ч.Хосбаяр шүүгчээр ахлуулсан ажлын хэсэг, Шүүгчдийн Холбооны Салбар тэргүүнүүд, шүүгч нарын төлөөллийг оролцуулан Удирдах зөвлөлийн гишүүд цахим уулзалт хийж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг

ШҮҮГЧ БИ:

Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахина.

/Шүүхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 "Шүүгчийн тангарагаас..."/

110 Авлигыг мэдээлэх УТАС

ШҮҮГЧИЙН хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд аливаа хэлбэрээр **НӨЛӨӨЛВӨЛ** хуулийн дагуу **ШИЙТГЭЛ** ногдуулна.

/Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4/

110 Авлигыг мэдээлэх УТАС

нэмэгдүүлэх, иргэдийн дунд үүссэн аливаа төөрөгдлийг арилгах, авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн хэд хэдэн төрлийн постер боловсруулж хэвлүүлсэн. Эдгээр постерыг хуулийн бусад байгууллагуудад түгээж байршуулах талаар Монголын Хуульчдын холбоотой хамтран ажиллав.

➤ **Төлөвлөгөөний 4.5-д: Шүүгчдийн Хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэгдсэнтэй холбоотой сургалт зохион байгуулав**

#Мэдээлэл
#ХОМ_мэдүүлэх_заавар

АТГ-аас гаргасан "Хувийн ашиг сонирхол болон Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах баталгаажуулах" талаар заавар видеог хүргэж байна.

YOUTUBE.COM
ХОМ-ийг хэрхэн үнэн зөв гаргах вэ?
ХОМ-ийг хэрхэн үнэн зөв гаргах теле хичээл#АТГ#Call110#ШүгэлҮлээцгээе! #АвлигынЭсрэг...

Alyeksandr Sarangerel, Sarantuya Adiyakhuu and 2 others

2024 оны 1-р сарын 30-нд Авлигатай тэмцэх газартай хамтран АТГ-ын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн ажилтан Ц.Баасандэлгэр "ХАСХОМ-ийн мэдүүлэг хэрхэн бөглөх" талаар цахим сургалтыг зохион байгуулсан. Мөн АТГ-аас гаргасан хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах баталгаажуулах заавар видео, гарын авлагыг МШХ, МШХ Салбар тэргүүн, болон бусад групп цахим хэрэгслээр шүүгчдэд түгээсэн байна.



PDF

ХОМ-ын Гарын авлага.pdf

➤ **Төлөвлөгөөний 4.6-д: МХХ-той, харилцан тохиролцсоны дагуу “Санамж бичиг” байгуулах, Шүүгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах**

2024 оны 3-р сарын 22-ны өдөр Гүйцэтгэх захирал Т.Туяа, ОНХ хэвлэл, мэдээллийн ажилтан М.Наранчимэг нар лхагва гарагт Хуульчдын холбооны байранд тус холбооны Ерөнхийлөгчтэй П.Одгэрэлтэй ажил хэргийн уулзалт хийв.

Уулзалтаар харилцан санал солилцож, хамтран ажиллахад шүүхийн хороо дэмжихгүй байгаа тул МХХ-ны Шүүхийн хорооноос 3 шүүгчийг “ярьж буй хууль” нэвтрүүлэгт оролцуулж нэвтрүүлгийн зардлыг төлөхөөр харилцан тохиролцсон. Үүний дагуу МХХ-ны Шүүхийн хорооноос Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Х.Ганболд, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Оюунбилэг нар оролцож зардал төлбөрийн талаар тус холбоонд албан бичиг явуулсан, одоогоор төлбөр төлөгдөөгүй байна.

Мөн гүйцэтгэх захирал албан бичгээр харилцаж, Шүүгчдийн холбоо, АТГ-ын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран гаргасан иргэдэд зориулсан сурталчилгааны посторыг хуулийн бусад байгууллагуудад (прокурор, өмгөөлөгч, нотариат г.м) түгээх ажилд туслалцаа үзүүлэн Холбооны сайтдаа байршуулан хамтран ажилласан юм.

➤ **Төлөвлөгөөний 4.7-д: Шихихутуг Их сургууль болон бусад их дээд сургуультай хамтран “mentorship” хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах**

Менторшип хөтөлбөрийг 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн явуулж, Эрүү, Иргэн, Захиргааны эрх зүйн процесс, хуулийн хэрэглээ хичээлийг анхан болон давж заалдах шатны шүүгчид Шихихутуг их сургуулийн оюутнуудад тогтсон цагаар зааж байна.

2023-2024 оны хичээлийн жил Менторшип хөтөлбөрийн хүрээнд Шихихутуг их сургуулийн 3-р курсийн 22 оюутныг Эрүү, Иргэн, Захиргааны шүүхийн 17 шүүгчид хуваарилж, оюутан тус бүртэй гэрээ байгуулан тэдэнд шүүхийн үйл ажиллагааг танилцуулж, практик ур чадварыг эзэмшүүлэв.

2024-2025 оны хичээлийн жил дадлагад хамрагдах 23 оюутныг 13 шүүгчид хуваарилсан байна.

Шихихутуг их сургуультай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хугацаа дуусаж 2024 оны 12-р сарын 17-нд “Хамтран ажиллах гэрээ”-г сунгаж талууд гарын үсэг зурсан.

Гэрээний онцлох заалтаас дурдвал:

1. Эрдэм шинжилгээ, судалгааны хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;
2. ШХИС-ийн магистр докторын зэрэг олгох сургалтад Холбооны гишүүн шүүгчдийг хөнгөлттэй нөхцөлөөр сургах
3. МШХ-ны гишүүн докторын зэрэгтэй шүүгчид ШХИС-д академик болон практик сургалтад оролцсон байдлыг харгалзан профессор, дэд профессорын цолыг ШХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр олгох
4. Магистр, докторын эрдмийн зэрэгтэй шүүгчийг ШХИС-д гэрээт багшаар ажиллах боломж олгох

Бусад: Шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, оюутан залууст практик дадлага эзэмшүүлэх зорилгын хүрээнд Отгонтэнгэр их сургуультай хамтран ажиллах талаар ярилцаж, “Хамтран ажиллах санамж бичиг” -ийн төсөл хүргүүлсэн байна.

➤ **Төлөвлөгөөний 4.8-д: “Шихихутуг Их сургууль”-тай хамтран Их дээд сургуульд багшлах эрх олгох сургалтад шүүгчдийг хамруулах**

Шихихутуг их сургууль нь Их, дээд сургуульд "Багшлах эрх олгох" сертификатын сургалтыг 2 ээлжээр явуулж нийт 30 шүүгч хамрагдаж 24 шүүгч

багшлах эрхийн үнэмлэхээ гардан авсан байна. Уг сургалтад холбооны гишүүдийг хамруулж бүртгэх болон бусад үйл ажиллагааг Шүүгчдийн холбооны ажлын алба хариуцан ажилладаг юм.



➤ **Төлөвлөгөөний 4.10-д: Гишүүн шүүгчдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх**

“Монголын Шүүгчдийн Холбоо” нь гишүүдийнхээ гадаад хэлний мэдлэгийг хөгжүүлэхийн тулд Шихихутуг Их Сургуультай хамтран төсөл бичиж Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамны олон нийттэй харилцах хэлтсээр дамжуулан Фулбрайтын “Англи хэлний туслах багшийн хөтөлбөр” /Fulbright English Teaching Assistant (ETA) program/-т хүсэлт илгээснээр амжилттай хэрэгжиж байна.

Тус хөтөлбөрийн “Англи хэлний туслах багшийн хөтөлбөр”-ийн болзол, шаардлагыг хангасан, Йэлийн их сургуулийг 2020-2024 онд Түүх болон Зүүн Ази судлалын хос мэргэшлээр төгссөн, АНУ-ын иргэн (native speaker) Maya Albold 2024 оны 9 сарын 1-нээс эхлэн 2025 оны 7 сарын 14 хүртэл Шүүгчдийн Холбооны гишүүн шүүгч нарт англи хэл сургалт зааж байна.

Англи хэлний сургалтад бүртгүүлсэн шүүгчид түвшин тогтоох шалгалт өгч, сургалт явуулах багштай уулзаж, танилцсан.



2024 оны 08 дугаар сарын 29-ны өдөр нийт сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн шүүгч нараас түвшин тогтоох шалгалтыг авч англи хэлний хоёр түвшинд хуваарилан дунд түвшин /B1/-д 20 шүүгч, анхан шатны түвшин /A1-A2/-д 18 шүүгч гэсэн хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Мөн орон нутгаас суралцагчид онлайнгаар анхан шатны түвшний хичээлд хамрагдав. */Хичээлийн сэдвийг хавсаргасан линкээр орж харна уу⁷/*.

Тус сургалт 2024-2025 оны хичээлийн жилийн 1-р улиралд нийт 17 долоо хоног Maya Albold хичээлийг удирдаж явуулав.

Сургалтыг явуулах анги, танхим, ном, сургалтын материал болон Америк багшийн өдөр тутам ажиллах ажлын өрөө, компьютер, техник, хэрэгслийг Шихихутуг Их Сургууль хариуцах бол багшийн Монгол Улсад байх хугацааны амьдрах орон сууцны түрээсийн зардлыг суралцагч шүүгч нар УЗ-өөс тогтоосон төлбөрийн хүрээнд хариуцсан байна.



МШХ болон Канадын шүүгчдийн холбооны хамтын ажиллагааны хүрээнд монголын шүүгч нарт Канадын ахмад шүүгч нар онлайнгаар англи хэлний харилцан яриа хийж шүүгч нарын Англи хэлний ярианы чадварыг сайжруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бүртгэл хийгдсэн. Хөтөлбөрт хамрагдахаар 27 шүүгч нэрээ хүсэлтээ ирүүлээд байна. Тус Англи хэлний ярианы чадвар сайжруулах хөтөлбөр нь шууд харилцан ярилцах хэлбэрээр явагдах тул тодорхой түвшинд

⁷https://docs.google.com/spreadsheets/d/173INx7bibKKJUZ_Ka2YYqK8Vw8sjRh4q/edit?usp=sharing&ouid=114899189345727073658&rtpof=true&sd=true


анхан шатны харилцан ярих чадвартай байх, Сургалт явуулах хугацаанд хичээл таслахгүй байх гэсэн шаардлагуудыг тавьж байна.

➤ **Төлөвлөгөөний 4.11-д: “Монголын Шүүгч Эмэгтэйчүүдийн холбоотой” хамтран ажиллах, Шүүгчдийн холбоотой нэгтгэх эсэх**

Монголын Шүүгч Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн Н.Дуламсүрэнтэй 2024 оны 12-р сарын 09-ний өдөр дээрх асуудлаар ажил хэргийн уулзалт хийж, цаашид зарим чиглэлээр хамтран ажиллах талаар ярилцав, харин нэгтгэх эсэх асуудлыг тухайн хорооны гишүүдээс санал авч дахин хэлэлцэхээр хойшлуулсан болно.

Тав. Холбооны дүрмийн 3.1.5-д заасан чиглэлээр⁸

➤ **Төлөвлөгөөний 5.1-д тусгасан: “Ярьж буй хууль” нэвтрүүлэг**



Шүүгчдийн холбоо нь шүүхийн үйл ажиллагаа, шүүгчдийн ажил, үүргийг олон нийтэд таниулах, иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор хүргэж буй “Ярьж буй хууль” теле нэвтрүүлгийг 59 дугаар бэлтгэсэн бөгөөд 2024 онд “Ярьж буй хууль” нэвтрүүлгийн нийт 19 дугаарын бичлэг хийж, 14 дугаарыг эфирт цацаж, 6 дугаарын монтаж хүлээгдэж байна. Нэвтрүүлгийг цахим сайтууд болон “ТВ-9”, “Соён гэгээрүүлэх”, “Өлзий”, “ТВ-24” зэрэг телевизээр цацаж хөтөлбөрийн дагуу олон нийтэд хүргэж байна.

⁸ 3.1.5. Гишүүдийнхээ үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр таниулах, энэ чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;



№45

Сэдэв: "ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ"

Шүүгч: ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ШҮҮГЧ Л.ЭНХБИЛЭГ

Зочин: СЭТГҮҮЛЧ Б.ТҮВШИНТӨГС



№46

Сэдэв: "МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО"

Шүүгч: ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ И.АМАРТӨГС

Зочин: ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН Н.ОТГОНЧИМЭГ



№47

Сэдэв: "ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРИЙГ ШҮҮХ ХЯНАХ УУ?"

Шүүгч: НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ Б.АДЪЯАСҮРЭН

Зочин: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН Д.БААТАРСАЙХАН



№49

Сэдэв: "ШҮҮХИЙН ЦАХИМЖИЛТ"

Шүүгч: НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Г.ДАВААДОРЖ

Зочин: ШЕЗ-ИЙН ГИШҮҮН Н.БААСАНЖАВ



№48

Сэдэв: "СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ИРГЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ"

Шүүгч: БЗД-ИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ Д.БАТЦЭЦЭГ

Зочин: "СҮНС" ХАМТЛАГИЙН АХЛАГЧ Б.ЛХАГВАСҮРЭН



№50

Сэдэв: "ЗАХИРГААНЫ ШҮҮХ
НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН
АВАХААС ТАТГАЛЗДАГ
ШАЛТГААН"

Шүүгч: УДШ-ИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ШҮҮГЧ Г.БАНЗРАГЧ

Зочин: ДУУРИЙН ГОЦЛОЛ ДУУЧИН,
СУИС-ИЙН БАГШ Б.БАТТӨР



№51

Сэдэв: "ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС
БАЙДАЛ, ЁС ЗҮЙ БА АВИЛГА"

Шүүгч: УДШ-ИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ч.ХОСБАЯР

Зочин: NTV ТЕЛЕВИЗИЙН "
ЛХАГВЫН ТОЙМ"
НЭВТРҮҮЛГИЙН СЭТГҮҮЛЧ
ГЛХАГВАДОРЖ



№52

Сэдэв: "ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ХЯНАЛТЫН ЦАР ХҮРЭЭ"

Шүүгч: ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ
ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧ М.ХОНИНХҮҮ

Зочин: МУГЖ, СИТИ ИХ СУРГУУЛИЙН
УРЛАГИЙН СУРГУУЛИЙН БАГШ
С.ӨЛЗИЙХҮҮ



№53

Сэдэв: "ТУСГАЙЛСАН ЖУРМААР
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА"

Шүүгч: УДШ-ИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ШҮҮГЧ Н.БАТЗОРИГ

Зочин: СИТИ ИХ СУРГУУЛИЙН СЭТГҮҮЛ
ЗҮЙН БАГШ СЭТГҮҮЛЧ (PHD) ДЭД
ПРОФЕССОР М.НАРАНЧИМЭГ

➤ **Төлөвлөгөөний 5.3-т: Шүүгчдийн холбоог дэмждэг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бусад ТББ-тай хамтран ажиллах, ажлын хэсэг байгуулах**

Хуульчдын сүлжээ:

ЮНЕСКО-ийн Хэвлэл мэдээллийг хамгаалах олон улсын сангийн дэмжлэгээр Хэвлэлийн хүрээлэнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөөх хуульчдын сүлжээний гишүүдийг чадавхжуулах хөтөлбөрийг эхлүүлж 4 удаагийн сургалт, форумыг зохион байгуулжээ.

Тус цуврал сургалтуудыг 2024 оны 10 сарын 18, 10 сарын 31, 11 сарын 21, 11 сарын 01-ний өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтад Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Эмнэсти Интернэшнл, Глоб Интернэшнл төв, Хууль зүйн Мэдээлэл, Судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг байгууллагууд оролцож, Шүүгчдийн Холбоог төлөөлөн Дорноговь аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Отгонтуяа, Төв аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Мөнхбүрэн, ажлын албаны төлөөлөл оролцов.



Төлөвлөгөөний 3.1, 5.4-д: Ахмадын дэд хороо санаачлан “дурсамж уулзалт”-ыг зохион байгуулсан



Шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, онцлогийг олон нийтэд таниулах зорилгоор ахмадын дэд хороо санаачлан 2024 оны 12-р сарын 14-нд Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хурлын танхимд Ахмадын дэд хорооны гишүүн Д.Наранцэцэг "Шүүхийн тогтолцооны өнгөрсөн-одоо" сэдвээр илтгэл тавьж оюутнууд сонирхсон асуултаа асууж, сэтгэгдлээ хуваалцав.

Уулзалтад Сити их сургуулийн оюутнууд, Шихихутуг их сургуулийн сэтгүүлч, эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутнууд, Шүүгчдийн холбооны ажлын алба, ахмад шүүгчдийн төлөөлөл дурсамж уулзалтыг зохион байгуулж оролцов.

Уулзалтын дараа оюутнууд Баянгол дүүргийн Иргэний шүүхийн хурлын бусад танхимтай танилцав.



Тус үйл ажиллагааг нэвтрүүлэг болгон бичлэг хийж оюутнуудын санал сэтгэгдлийн хамт youtube-д байршуулсан байна⁹.


⁹ Шүүхийн тогтолцооны өнгөрсөн одоо дурсамж уулзалт-
<https://youtu.be/XTcVK0zZci0?si=ICGea-t-wFmN5J2R>

Зургаа. Холбооны дүрмийн 3.1.7-д заасан чиглэлээр¹⁰

- Төлөвлөгөөний 6.1-д: ШЕЗ-ийн 2023-6-29-ний 207 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ын талаар шүүгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэх, ШЕЗ-тэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хамтран ажиллах

ШХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.1-д “ШЕЗ-ийн 2023-6-29-ний 207 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ын талаар шүүгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэх, ШЕЗ-тэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хамтран ажиллах” хэмээн тусгагдсан.


Энэ талаар Холбооны гүйцэтгэх захирлын 2023 оны 12-р сарын 26-ны өдрийн №29 дугаар тушаалаар:



1. УЗ-ийн гишүүн, Нийслэлийн ЭХДЗШШ-ийн шүүгч Г.Ганбаатар
2. УЗ-ийн гишүүн, Нийслэлийн ЭХДЗШШ-ийн шүүгч Ц.Оч
3. УЗ-ийн гишүүн, БЗДЭХАШШ-ийн шүүгч Н.Одонтуул
4. Нийслэлийн ИХДЗШШ-ийн шүүгч Э.Энэбиш
5. СХДИХАШШ-ийн ерөнхий шүүгч Б.Хишигбаатар
6. ЗХДЗШШ-ийн шүүгч Н.Долгорсүрэн
7. Нийслэл дэх ЗХАШШ-ийн ерөнхий шүүгч Н.Дуламсүрэн нарын бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг” байгуулсан.

¹⁰ 3.1.7. Шүүгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бол гишүүдийн талаарх мэдээллийг цаг тухайд нь судалж, тухайн гишүүний хүсэлтийг үндэслэн хариу мэдээлэх;

Ажлын хэсгийн шүүгч нар 2024 оны 01 дүгээр сарын 05-нд хуралдаж цахим хурал хийж “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ын хүрээнд үүссэн ойлгомжгүй, тодорхойгүй асуудлыг тодруулах, тухайн журмыг боловсронгуй болгох асуудлаар салбар хороод саналаа нэгтгэж ирүүлэх талаар холбооны гишүүн шүүгчдийн групп цахим хэрэгслээр мэдээлэл тавьсан.



Дээрх мэдээллийн дагуу СХДИХАШШ, ЧДИХАШШ, Багануур дүүргийн ЭИХАШШ, Сүхбаатар аймаг, Архангай аймаг, Булган аймаг, Хэнтий аймаг, Сэлэнгэ аймаг, Дундговь аймаг, Говь-Алтай аймгийн шүүхээс ирүүлсэн саналыг ажлын хэсгийн шүүгч нарт хүргүүлсэн болно.

Түүнчлэн 2024 оны 1-р сарын 12-нд Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Ганбаатар, Ц.Оч, болон ажлын хэсэгт орсон ЗХАШШ-ийн Ерөнхий шүүгч Н.Дуламсүрэн, гүйцэтгэх захирал Т.Туяа, ОНХ, хэвлэл мэдээллийн ажилтан М.Наранчимэг нар ШЕЗ-ийн дарга Л.Энхбилэг, гишүүн А.Отгонцэцэг, Э.Зоригтбаатар, А.Насандэлгэр, Н.Баасанжав нартай дээрх асуудлаар уулзалт хийв. Уулзалтаар ШЕЗ-ийн дарга Л.Энхбилэгт хүндэтгэл үзүүлж, шүүгч нарын ачаалал тооцох, зохист ачааллаас илүү цагт олгох цалин хөлсний талаарх журмыг хэрхэн тооцож байгаа талаар шүүгчдийн ирүүлсэн дээрх саналыг тоймлон танилцуулж, энэ хүрээнд үүссэн ойлгомжгүй, тодорхойгүй асуудлын талаар хэлэлцүүлэг хийв.



Долоо. Холбооны дүрмийн 3.1.8-д заасан чиглэлээр¹¹

➤ Төлөвлөгөөний 7.3-д: Нийт шүүгчдийг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах

Шүүгчдийн холбооноос шүүгч гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж ТТАХНЭ болон ХСҮТ төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулав. Уг гэрээний дагуу орон нутгийн 13 салбар хороодоос ирүүлсэн бүртгэлийг үндэслэн 2024 оны 4-р сарын 19-нд ТТАХНЭ, 4-р сарын 20-нд ХСҮТ-ийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 100 гаруй шүүгч нар хамрагдахаар хүсэлтээ өгснөөс 83 шүүгч үзлэгт хамрагдсан байна.

Шүүгчдийн холбооны зүгээс шүүгчдийн эрүүл мэндийн байдалд анхаарч урьдчилан сэргийлэх үзлэгийг салбар хороод болон шүүгчдээс ирүүлсэн саналыг үндэслэн жил бүр зохион байгуулж буй бөгөөд үзлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан шүүгч нарыг нэгдсэн журмаар үзлэгт хамруулж оочир дугааргүй үзүүлэх цаг хэмнэх давуу талтай юм.

¹¹ 3.1.8. Гишүүддээ сэтгэл санааны болон эд материалын туслалцаа үзүүлэх;

ХСҮТ-д үзлэгт хамрагдсан шүүгч (хүйсээр)			
Эмнэлэг	Нийт	Хүйс	
ХСҮТ	72	Эм	54
		Эр	18
ТТАХНЭ	11	Эм	7
		Эр	4

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний дагуу ХСҮТ-ийн өгсөн зөвлөмж:


Толгой хүзүүний хавдрын мэс заслын эмчийн үзлэг, оношилгоогоор холбооны гишүүдийн дунд бамбайн зангилааны тархалт өндөр буюу 59.7 хувьд илэрсэн ба уг үзүүлэлт нийт хүн амын дундах тархалтаас даруй 19.7 хувь өндөр гарчээ (нийт хүн амын дунд уг эмгэгийн тархалт 50 хувьтай байдаг). Бамбайн зангилаа нь ихэнх тохиолдолд шинж тэмдэггүй ба хүндэрсэн үед хоолой барьсан мэдрэмж төрөх, залгихад саадтай мэт санагдах, хэмжээ нь томорсон үед амьсгалахад хэцүү мэдрэмж төрдөг байна. Нийт зангилааны ойролцоогоор 95 хувь нь хоргүй, 5 хувь орчим нь хортой зангилаа байдаг. Үзлэгийн дүнд бамбайн зангилаа оношлогдсон хүн тус бүрд гурван сараас нэг жил хүртэл хугацаанд дахин хянуулах зөвлөмжийг өгсөн ба дөрвөн хүнд онош тодруулж зангилаанаас хатгалт хийж эдийн шинжилгээ өгөх мөн цаашид урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр гишүүдийг хамруулахыг чухалчлан зөвлөсөн байна.

Холбооны гишүүдийг хувьчилсан сэтгэл зүйн ярилцлага, зөвлөгөөнд хамруулах, стресс, уур бухимдлаа хэрхэн тайлах зэрэг сургалт, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, жил бүр эрүүл мэндийн цогц урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх тухай саналыг эмч нарын зүгээс анхааруулж зөвлөсөн болно.

№	Үзүүлэлт	Тоо	Хувь
1	Эрүүл мэндийн эрсдэлтэй	12	16.6 %
2	Нэмэлт шинжилгээ шаардлагатай (онош тодруулах)	6	8.3 %
3	Амбулаториор эмчлүүлэх шаардлагатай	4	5.5 %
4	Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай	-	-

5	Сувилалд эмчлүүлэх шаардлагатай	-	-
---	---------------------------------	---	---

Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах талаар нийт салбар хороо тэдгээрийн тэргүүнд түгээсэн боловч нийслэл дүүргийн шүүхүүдээс үзлэгт хамрагдах талаар хүсэлт ирүүлээгүй, Урьдчилан сэргийлэх үзлэг нь нэгдсэн журмаар явагдаж тухайн эмнэлгийн зүгээс амралтын өдрөөр эмч эмнэлгийн зүгээс зөвхөн хамтын ажиллагааны хүрээнд шүүгчдийг хүлээн авч тухайн үзлэг шинжилгээг хийж шүүгчдийн цаг хугацааг хэмнэсэн. Эмнэлгээс ирүүлсэн зөвлөмжийг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шүүгчдийн эрүүл мэндийн талаар онцгой анхаарч хамтран ажиллах талаар ШЕЗ-д дараах албан бичгийг хүргүүлсэн:



МОНГОЛЫН
ШҮҮГЧДИЙН ХОЛБОО

Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжидсаяаны гудамж, Хангарал ордон
Шүүгчдийн холбооны байр, 4 давхар, 404 тоот
Утас: 70114100, +976 92114100
E-mail: contact@judge.mn

2024.07.20 № *20*

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛД

САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ


Монголын Шүүгчдийн холбооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөт ажлын хүрээнд шүүгч гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвтэй Хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн 120 шүүгчийн бүртгэл хийж тухайн шүүгч нарын хувийн зардлаар 2024 оны 04 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд үзлэг, шинжилгээ оношилгоонд хамруулсан болно.

Хавдар судлалын үндэсний төвийн урьдчилан сэргийлэх үзлэгийн онцлох дүгнэлтээр тус төвд үзлэгт хамрагдсан нийт 72 шүүгчээс хөхөнд хавдрын үүсгэвэртэй 2, бамбай хавдар сэжиглэгдсэн 4, эмэгтэйчүүдийн хавдрын урьдал эмгэг 2, эрүүл мэндийн эрсдэлтэй 12, нэмэлт шинжилгээ хийж онош тодруулах шаардлагатай 6, толгой хүзүүний хавдрын мэс заслын эмчийн оношилгоо үзлэгээр холбооны гишүүдийн дунд бамбайн зангилааны тархалт өндөр буюу 59.7 хувьд илэрсэн ба уг үзүүлэлт нийт хүн амын дундах тархалтаас даруй 19.7 хувь өндөр байгаа төдийгүй хоол боловсруулах болон зүрх судасны эрхтэн тогтолцооны архаг эмгэг, өвчлөл зонхилж байгааг илрүүлж үүнд онцгойлон анхаарах талаар зөвлөсөн байна.

Мэргэжлийн эмнэлгийн дээрх зөвлөмжид тусгагдсанаар онош тодруулах шаардлагатай эмгэг оношлогдсон гишүүдийг нэн даруй цаг алдалгүй нэмэлт оношилгоо шинжилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх, нийт шүүгчдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, байгууллагын зүгээс эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн ярилцлага, зөвлөгөө, зохион байгуулж, стресс уур бухимдлаа хэрхэн тайлах сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хувь хүн өөрөө эрүүл амьдралын хэв маягт суралцаж хэвшүүлэх, илэрсэн эмгэгийг эрүүлжүүлэх, хүндрүүлэхгүй байх, эрүүл мэнддээ хариуцлагатай хандаж байхыг илэрхийлжээ.

Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 05-ны ээлжит хурлаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн талаар гаргасан ХСҮТ-ийн дээрх тайлан дүгнэлт, зөвлөмжийг танилцуулсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлд энэ тухай мэдэгдэж нийт шүүгчдийн ажлын ачаалалтай хамааралтайгаар тэдний эрүүл мэндийн байдалд онцгой анхаарч урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр үнэ төлбөрийг нь даатгалын сангаас гаргуулан хамруулж байх санал гаргасныг үүгээр уламжилж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Т.ТУЯА*



- **Төлөвлөгөөний 7.4-т: МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар өндөр насны тэтгэвэрт гарч буй ахмад шүүгчдэд холбооны дүрэмд заасны дагуу хүндэтгэл үзүүлэх**

Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 17-ны 08 дугаар тогтоолоор баталсан Шүүгчдийн холбооны гишүүн шүүгч нарт тусламж, дэмжлэг үзүүлэх журмын 2.1 дэх хэсэгт зааснаар 2024 онд Ерөнхийлөгчийн зарлигаар өндөр насны тэтгэвэрт гарсан болон өмнөх онуудад тэтгэвэрт гарч урамшуулал олгогдоогүй нийт 18 шүүгчдэд хүндэтгэл үзүүлж, шүүгч тус бүрт 200,000₮ буюу нийт 3,600,000₮-н мөнгөн урамшуулал, 684,000₮-н дурсгалын зүйл /холбооны лого бүхий үзэг/-ийг тухайн шүүгч болон салбар хороодын тэргүүн нарт олгосон байна.



Найм. Холбооны дүрмийн 3.1.9-д заасан чиглэлээр¹²

- **Төлөвлөгөөний 8.1-д тусгасан: Холбооны үйл ажиллагааг дэмжиж гишүүнчлэлээ хэвээр хадгалж буй ахмад шүүгчидтэй хамтран ажиллах**

Монголын Шүүгчдийн Холбооны дүрмийн 5.1, 5.7, 5.9.8, 5.10, 10.2, 10.3.8-д заасныг баримтлан, Удирдах зөвлөлийн хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Шүүгчдийн Холбооны дүрмийн 10.2-г заасны дагуу хүсэлтээ ирүүлсэн нэр бүхий 13 ахмад шүүгчийг холбооны гишүүнээр бүртгэж, Шүүгчдийн Холбооны дүрмийн 5.9.8-д заасны дагуу нэр бүхий 13 шүүгчээс бүрдсэн “Ахмадын дэд хороо”-г байгуулсан.



2024 оны 01-р сарын 19-нд Удирдах зөвлөлийн гишүүн Г.Ганбаатар болон ажлын алба ахмад шүүгч нарыг хүлээн авч анхны уулзалтаа хийж 2024 оны холбооны үйл ажиллагаанд тусгагдсан төлөвлөгөөтэй танилцан, “Ахмадын дэд хороо”-ны ахлагчаар ахмад шүүгч А.Мөнхзулыг сонгов. Ахмадын дэд хорооны Шүүгчдийн холбооны Удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн

¹² 3.1.9. Хууль, дүрэмд заасан бөгөөд Төрийн бус байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагааны хэлбэр;

баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Холбооны дүрмийн 3.1.2 чиглэлээр “Шүүгчийн мэдлэг боловсрол, шүүн таслах үйл ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх”, 3.1.5 чиглэлээр “гишүүдийнхээ үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр таниулахад дэмжлэг үзүүлэх”-д хамтран санаачлагатай ажиллахаар уулзалтаар хэлэлцэж санал нэгдсэн байна.

Шүүгчдийн Холбооны дүрмийн 10.3.8-д зааснаар Ахмадын дэд хорооны шүүгчийг холбооны гишүүний татвараас 50 хувиар чөлөөлж, бүртэлд орсон өдрөөс гишүүний татвараа төлж, Шүүгчдийн холбооноос зохион байгуулах бүхий л үйл ажиллагаанд оролцох боломжтой юм. Тайлангийн хугацаанд тэтгэвэрт гарсан шүүгчдээс гишүүнээр хэвээр хадгалахаар хүсэлт гаргасан шүүгчийн хүсэлтийг хүлээн авч “ахмадын дэд хороо” нь 23 гишүүний бүрэлдэхүүнтэй болсон байна.

2024 оны 3-р сарын 14-ний өдөр Ахмадын шүүгч нар уулзалт хийж дэд хорооны ажлах журмын хэлэлцэж МШХ-ны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан ахмад шүүгч нарт хамаарах ажлын талаар ярилцаж хийх ажлын төлөвлөгөөг тусгайлан гаргав.

❖ *Мод тарив*

2024 оны 05-р сарын 11-ны өдөр Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрт Монголын Шүүгчдийн холбооны ахмадын дэд хорооны шүүгчид хамрагдаж мод тарих аянд өөрсдийн хувь нэмрээ



оруулсан.



❖ Монгол банкны “Эрдэнэсийн сан”

Ахмадын дэд хорооны гишүүд санаачлан 2024 оны 10-р сарын 16, 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд Монгол улсын үнэт өв, мөнгөн тэмдэгтийн түүхэн замналыг дэлгэсэн Монгол банкны “Эрдэнэсийн сан” болон төлбөрийн хэрэгслийн түүхийг харуулсан “Мөнгөн тэмдэгт”-ийн үзмэрийг үзэж сонирхсон байна.




3.1 Бусад

❖ УЗ-ийн Тэргүүний нөхөн сонгууль

МШХ-ны Удирдах зөвлөлийн 2024 оны 11-р сарын 20-ны өдрийн хурлаар Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг нөхөн сонгох нөхцөл байдал үүссэн талаар хэлэлцэж сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг УЗ-ийн тогтоолоор баталсан байна.

Ажлын хэсэг 2024 оны 11-р сарын 28-ны өдөр хуралдаж, уг ажлын хэсгийн ахлагчаар ЗХАШШ-ийн шүүгч У.Бадамсүрэн томилсноор, сонгууль зохион байгуулах журам, сонгуулийн саналын хуудас болон сонгууль явуулах санамж бичиг загвар зэргийг хэлэлцэж батлав.

Сонгуулийг 2024 оны 12-р сарын 03-ны өдөр салбар хороодын хэмжээнд зохион байгуулж, 12-р сарын 06-ны өдрийн дотор саналын хуудсыг баталгаат шуудангаар ирүүлэн, 12-р сарын 10-ны өдөр ажлын хэсэг хуралдаж саналыг тоолж дүнг баталгаажуулан тогтоол үйлдсэн.



Тооллогын комиссын тогтоол
2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр
Улаанбаатар хот

Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг сонгох нөхөн
сонгуульд санал авсан нэр дэвшигчдийн дүнг хүргүүлэх тухай

Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг сонгох нөхөн сонгуульд нийт 468 гишүүн-шүүгчдийн санал ирснийг тэмдэглээд, Монголын Шүүгчдийн Холбооны дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.3, тус холбооны Удирдах Зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг сонгох нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" 06 дугаар тогтоолын 2, 3 дахь заалтыг үндэслэн Ажлын хэсгийн хуралдаанаас байгуулагдсан Тооллогын комиссоос ТОГТООХ НЬ.

Нэг. Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг сонгох нөхөн сонгуульд нийт 468 шүүгч-гишүүд санал ирүүлснээс нэр дэвшигч шүүгч Д.Батбаатар 280 санал, нэр дэвшигч шүүгч Ц.Оч 175 санал, хүчингүй 13 санал тус тус тоологдсоныг тогтоосугай.

Хоёр. Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнийг сонгох нөхөн сонгуулийн нэгдсэн дүнг Ажлын хэсгийн ажиллах журамд зохицуулсны дагуу хүснэгтлэн гаргаж Удирдах Зөвлөлд танилцуулах болон хүргүүлэхийг Ажлын албанд үүрэг болгосугай.

Тооллогын комиссын ахлагч

Шүүгч У.Бадамсүрэн

Тооллогын комиссын гишүүд

Шүүгч В.Амартүвшин

Шүүгч Д.Батцэцэг

Шүүгч А.Цэрэнханд

Шүүгч Ц.Эрдэнэчимэг

Шүүгчдийн холбооны тэргүүнд салбар хороодоос УДШ-ийн шүүгч Д.Батбаатар, НЭХДЗШШ-ийн шүүгч Ц.Оч нарын нэрийг дэвшүүлснээр холбооны гишүүн шүүгч нарын дунд санал хураалт явагдаж, 40 салбараас нийт 468 шүүгч-гишүүд саналаа ирүүлснээс нэр дэвшигч шүүгч Д.Батбаатар 280 санал, нэр дэвшигч шүүгч Ц.Оч 175 санал, хүчингүй 13 санал тус тус тоологдсон байна.

Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар тооллогын комиссын Тогтоолыг хүлээн авч, Монголын Шүүгчдийн Холбооны Тэргүүнд нэр дэвшигдсэн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Д.Батбаатарыг тус холбооны Тэргүүнээр сонгогдсоныг баталгаажуулав.

Гүйцэтгэх захирал холбооны дүрэмд зааснаар тус холбооны тэргүүнээр 2024 оны 12-р сарын 19-нд улсын бүртгэлд бүртгүүлэв.

❖ Шүүгчдийн Холбоо нүүв

Хангарди ордонд засвар хийх болсноор Шүүгчдийн холбоо ЧД-ийн 5-р хороо, Тэнгис кино театрийн ард, Orange plaza-ийн 6 давхар, 602 тоотод үйл ажиллагаагаа түр хугацаагаар явуулах болов. Гишүүн шүүгчид ажил хэргийн талаар аливаа уулзалт хийх шаардлагатай үед ажлын албатай шууд холбогдон холбооны байранд хүрэлцэн ирэх боломжтой юм.



❖ Монгол Улсын авлигатай тэмцэж буй бодлого, үйл ажиллагаанд олон улсын шинжээчид үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцов

Монгол Улсын авлигын эсрэг хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, үнэлгээ хийх зорилгоор Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас томилогдсон олон улсын шинжээчдийн баг Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторинг хийхээр Монгол улсад ирж ажиллаж буйтай холбогдуулан Шүүгчдийн холбоонд АТГ-аас өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хүргүүлсэн тайланг хамгаалах, шинжээчдийн багаас тавьж буй холбогдох асуултад хариулт өгөх албан тушаалтныг оролцуулах тухай албан бичиг ирсний дагуу 2024 оны 4-р

сарын 10-ны өдөр Удирдах зөвлөлийн гишүүн, НЭХДЗШШ-ийн шүүгч Ц.Мөнхтулга, БЗДЭХАШШ-ийн ерөнхий шүүгч Н.Одонтуул нар холбоог төлөөлөн оролцсон юм.

Станбулын авлигын эсрэг арга энэхүү арга хэмжээний төлөвлөгөөг 2003 оноос эхэлж Авлигын эсрэг сүлжээнд нэгдсэн улс оронд үнэлгээ хийх замаар дэмжлэг үзүүлж, Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон бусад олон улсын стандарт, сайн туршлагыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор оролцогч улсуудад зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд тасралтгүй үнэлгээ хийдэг хөтөлбөр юм.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 4 удаагийн үнэлгээг хийлгэж, 2014, 2019 онуудад холбогдох зөвлөмжийг хүлээн авч эрх бүхий байгууллагад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллажээ.



❖ **“Шүүх болон хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг сайжруулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлэгт оролцов**

2024 оны 12-р сарын 06-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагатай хамтран Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод

байдал” төслийн хүрээнд “Шүүх болон хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг сайжруулах арга замууд” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг болов.


Энэхүү уулзалтад Шүүгчдийн холбоог төлөөлөн УЗ-ийн гишүүн, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Мөнхтулга “Шүүн таслах ажиллагааны үндэслэл журам” сэдвээр илтгэл тавьж, “Шүүх ба хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлууд, сайжруулах арга замууд” танхимын хэлэлцүүлэгт оролцон илтгэлийн хүрээнд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулав.

Тус уулзалтад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид, хуульч, эрх зүйч, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон юм.



Төлөвлөгөөний биелэлт

Шүүгчдийн холбооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 34 ажил тусгаснаас 27 ажил биелж, 7 ажил биелээгүй байна.



Биелээгүй төлөвлөгөө		
№	Төлөвлөгөө	Тайлбар
1.3	УЗ-ийн гишүүд, салбар хороодын тэргүүн нартай хамтарсан уулзалтыг цахимаар зохион байгуулах	Төлөвлөгөөг сануулж УЗ-ийн хурлаар хэлэлцэж байсан, салбар хороодын бүсчилсэн хуваарийг УЗ-ийн гишүүдэд имэйлээр илгээсэн
4.2	“Япон, /Солонгос/ болон гадаадын шүүх, эрх зүйн боловсролын тогтолцоотой танилцах аялалыг зохион байгуулах	Биелэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

4.6	МХХ-той, харилцан тохиролцсоны дагуу “Санамж бичиг” байгуулах, Шүүгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын хэсэг байгуулах	Хамтран ажиллах талаар дэмжээгүй. МХХ-ны Шүүхийн хорооноос 3 шүүгчийг “ярьж буй хууль” нэвтрүүлэгт оролцуулж нэвтрүүлгийн зардлыг төлөхөөр харилцан тохиролцсон. Одоогоор төлбөр төлөгдөөгүй байна.
4.9	АНУ Элчин Сайдын яамтай хамтран ажиллаж АНУ-ын төрийн департаментаас зохион байгуулдаг “АНУ-д төгсөгчдөө дэмжих” хөтөлбөрт хамрагдах, бичиж хүргүүлсэн төсөлд хариу авч, үргэлжлүүлэх /Ярьж буй хууль/	-
5.2	Орон нутгийн телевизүүдтэй гэрээ байгуулж “Ярьж буй хууль” нэвтрүүлгийг цацах талаар гэрээ байгуулах	Гэрээ байгуулаагүй.
7.1	Шүүгчдийн холбооны ахмад гишүүн шүүгчдийг Төрийн одон медаль, системийн бусад шагналд шагнуулах эсэхэд холбоо ямар оролцоотой байхыг судлах ажлын хэсэг байгуулах	-
7.2	Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон Салбар хороод, гишүүдийг урамшуулах	-

